

Хүйтэн дайны үе шувтарч, улс орнууд үзэл суртлын тэмцлээс ангижирч, дэлхийн олонх оронд ардчилал хөгжиж, чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлсэн нь дэлхийн улс орнууд тухайлбал АНД-н орнуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжийг улам өргөжүүлэх таатай нөхцөл уур амьсгал бий болгож өглөө.

Дэлхий дахины анхаарлын төв өнөөдөр АНУ-д шилжиж хурд явц нь эрчимжиж, XXI зуун АНД-н орнуудынх болох гэж байгаа талаар дотоод, гадаадын олон эрдэмтэн бичиж үнэлэлт дүгнэлтээ өгч байна.

Тэд өөрсдийн дүгнэлтийг дараах байдалд тулгуурлан хийж байгаа юм. Өнөөдөр АНУ-д дэлхийн хүн амын 50 % байрлаж, «Ази номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын» гишүүд дэлхийн үйлдвэрлэлийн 50 % -ийг гаргаж, улмаар тэнд дэлхийн хэт их гүрэн байсан хоёр орон, дэлхийн эдийн засгийн их гүрэн болох Япон, үйлдвэрлэл худалдаа хөгжсөн Азийн барууд, мөн НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын 3 гишүүн багтаж байна. Иймээс дэлхий дахины анхаарал, хараа ирээдүйн соёл иргэншил, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа стратегийн төв болох АНД-д тусч байна.

**Нэг: АНД-н орнуудын улс төр, эдийн засаг,
байгаль орчны өнөөгийн байдал, ирээдүй**

А. Улс төрийн байдал

Өнөөдөр дэлхий дээр ганц хэт их гүрэн АНУ үлдэж түүний араас тэмүүлж байгаа гүрэн бол Япон, Герман, Хятад, Энэтхэг болно.

Хэдийгээр хүйтэн дайны үе шувтарч буй боловч Азид зарим нэгэн үлдэгдэл хэвээр хоцорлоо. Азид үймээн хөдөлгөөн, мөргөлдөөн үүсч болох хэд хэдэн цэг байгаагаас гол цэг нь Орос орон. Тэнд үймээн хөдөлгөөн гарваас төв болон зүүн Хойт Азид шууд нөлөөлж байдлыг тогтворгүй болгох аюултай байна. Чөлөөт, ардчилсан сонгууль явуулж улс орныхоо дотоод байдлыг хэвийн болгох хүчин Орос оронд бий.

Дараачийн цэг бол Солонгосын хойг. Тэнд байдал тогтворгүй байна. Ялангуяа БНАСАУ цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээнээс гарч, олон улсын, атомын эрчим хүчний үзлэгийг өөрийн оронд хийлгэхээс татгалзаж байгаа нь байдлыг хурцатгаж магадгүй байна. Гэвч эрүүл саруул ухаан ялж Пхеньян дээрх байр сууринаасаа няцаж, АНУ түүний хариуд БНАСАУ-тай харилцаагаа хэвийн болгож болох дэлхий дахины ерөнхий уур амьсгал өнөөдөр бүрдсэн байна гэж үзэж болох юм.

Гуравдахь цэг нь Өмнөт Хятадын тэнгис, Камбожийн дотоод хүчнүүдийн тэмцэл болно. Камбожид Н. Сианукийн роль үүрэг, сүүлийн үед түүний гаргаж байгаа санал, байр суурь нь найдвар төрүүлж байна.

Ийнхүү хэд хэдэн түгшүүрийн цэг Ази тивд байгаа авч Ази, Номхон далайд дайныг өдөөн хатгасан улс орон, хүч байхгүй гэж үзэж болох талтай. АНД-н орнуудын улс төрийн уур амьсгал ерөнхийдөө сайжирч, тэд худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын салбарт хамтын

* Гадаад харилцааны яамны ажилтан

ажиллагааг эрхэмлэж байна. Өөрөөр хэлбэл Азид хэн ч дайныг хүсэхгүй байгаа бөгөөд тэр нь XXI зууны АНД-н орнуудын хамтын ажиллагааны үндэс суурь нь болох юм.

Б. Эдийн засаг

Өнөөдрийн дэлхий дахинд зөрчил, хуваагдмал байдал оршин тогтсоор байгаа авч, түүнийгээ хоёрдугаарт тавьж ерөнхийдөө худалдаа, эдийн засгийн интеграцид орж эхэллээ.

Дэлхий дахинд бий болж байгаа бүс нутгийн эдийн засгийн чөлөөт бүсүүд нь (Европын холбоо, хойт Америкийн чөлөөт худалдааны хэлэлцээр) үргэлж чөлөөтэй, нээлттэй байж өөр хоорондоо хамтын ажиллагаа явуулах нь дэлхийн улс түмнүүдийн эрх ашигт нийцэх юм. Харин бүс нутгийн чөлөөт худалдааны бүсүүд зөвхөн өөрсдийн эрх ашгийг эрхэмлэн явцуухан байдалд зохицуулан өөрсдийнхөө үйл ажиллагааг явуулах аваас дэлхий нийтэд тогтсон нааштай уур амьсгалд сөргөөр нөлөөлж болох юм. Ийм байдалд орохгүйн тулд бүс нутаг бүрд худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага байгуулахыг дэмжиж, тэднийг хооронд нь холбосон дэлхийн худалдаа эдийн засгийн олон талт чөлөөт бүсийг XXI зуунд байгуулах боломж бүрдэнэ гэдэгт итгэнэ. Түүнийг хэрэгжүүлэхэд АНД-н бүс нутгийн орнууд болон «АПЕК», «ПЕКК» тодорхой үүрэг гүйцэтгэх боломжтой юм.

Азийн орнуудын эдийн засгийн байдлыг ерөнхийд нь тодорхойлбол: Жар, далаад оны үед Япон эдийн засгийн хувьд дэлхийн хэт их гүрэн болж түүний араас өмнөд Солонгос, Тайвань, Гонгконг, Сингапур өндийн өсч улмаар наяд оны үед тэр нь улам өргөжин Малайзи, Тайланд, Индонез, Хятадыг хамарлаа. Эдгээрээс гадна эдийн засгийн боломж, нөөцөөрөө асар их Энэтхэг улс мөн өндийж бослоо.

Ийнхүү АНД-н орнуудын худалдаа, эдийн засгийн үүрэг нөлөө, дээшилж, тэдний эдийн засаг хурдан өсөлттэй байж, улмаар ард түмний нь амьдралын түвшин сайжирч эхэллээ. Тухайлбал сүүлийн 20 жилд дэлхийн экспорт дахь Азийн орнуудын экспортын хувийн жин 11 % байснаа 22 % болж өссөний зэрэгцээ импорт ч дээрхийн хэмжээгээр нэмэгдсэн байна. Мөн нийт үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээгээр АНД-н орнууд дэлхийд дээгүүр орж байна.

Дэлхий дахины болон АНД-н орнуудын өөр нэгэн сонирхол бол Орост явагдаж байгаа эдийн засгийн шинэчлэлийг амжилттай, эргэлт буцалтгүй болгоход анхаарал тавьж ач холбогдол өгч байгаад оршино.

Нөгөөтэйгүүр БНХАУ-ын эдийн засгийн өсөлт, эдийн засгийн чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг дэмжиж, тэнд өөрсдийн хөрөнгө оруулалтын бодлогоо хөхүүлэн урамшуулж байна.

Түүнчлэн Монголд явагдаж буй чөлөөт зах зээлийн бодлогыг дэмжин хандивлагч орнуудын хэд хэдэн удаагийн уулзалтыг Японы засгийн газар Дэлхийн банк, хамтран зохиосон явдал туйлын ач холбогдолтой боллоо. Өнөөдөр хөгжилтэй орнуудын зах зээлийн бодлого, менежментийн онолыг бид сохроор хуулбарлах нь ЗХУ-д социалист эдийн засаг хөгжүүлснийг хуулсантай туйлын төсөөтэй байна. Харин түүний оронд хөгжилтэй зах зээлийн эдийн засаг хөгжсөн орны онол, практикийн юу нь бидэнд тохирох, юу нь тохирохгүйг ялган тунгааж харин бидэнтэй хөгжлийн түвшингээр төсөөтэй ижилхэн, асуудлыг шийдэхийн төлөө тэмцэж буй хөгжиж байгаа орнууд нь уг асуудлыг хэрхэн шийдэж, ажиллаж байгааг анхааралдаа аван ажиллах цаг манай орны эдийн засагч, хуульч хүмүүсийн өмнө тулгараад байна.

3. Байгаль, орчны бохирдолт, ДОХ-ын байдал

Өнөөдрийн дэлхий дахины санаа сэтгэлийг зовоож, тэднийн өмнө тулгарч байгаа нийтлэг асуудал бол байгаль орчны бохирдолт XXI зууны тахал-дох, хар тамхи, дүрвэгсдийн асуудал юм. Дэлхийн байгаль орчны хямрал нь дэлхий нийтийн дулааралт, озоны хүрээ шавхагдах, хүчиллэг бороо орох, цөлжих, ой модны хэмжээ багасах, байгалийн үзэсгэлэнт орчин устаж алга болох зэргээр илэрч байна. Эдгээртэй хамтран бүх нийтээрээ тэмцэхийн ач холбогдол чухлыг хүн төрөлхтөн бүр ойлгож байгаа тодорхой жишээ нь 1993 оны 6 дугаар сард Бразилд болсон . 180 гаруй орнуудын уулзалт гэрчилж байгаа болно.

Байгаль орчныг бохирдолтоос хамгаалах явдал АНД-н орнуудын өмнө тулгарч байгаа чухал зорилтуудын нэг гэдгийг Японы засгийн газар ухамсарлан улмаар «АНД-н орнуудын байгаль орчны их хурал» , гэдгийг 1993 онд зохиож байгаль орчныг хамгаалахын зайлшгүй шаардлагыг оролцогч орнуудад дахин нэг сануулж, байгаль орчныг бохирдолтоос хамгаалахад зориулсан өөрийн техник, технологийг үзүүлж, цаашид хамтран ажиллах үндсийг тавилаа.

Хүн төрөлхтөнийг аюулд учруулж байгаа XXI зууны тахал бол дох юм. ДЭМБ-ын тооцоогоор бол уг өвчний бактерийг тээгчдийн тоо 2000 онд 30—40 саяд хүрэх төлөвтэй байна. Ази, Африкийн орнуудад уг өвчнөөр өвчлөгчдийн тоо улам нэмэгдэж байгаа нь АНД-н орнуудаас хамтын ажиллагааны ихээхэн хэмжээний хүч чармайлт гаргахыг шаардаж байна. Энэ талаар АНД-н орнууд XXI зуунд хамтын ажиллагааны шинэ арга хэлбэртэй болж хамтын хүчээр уг тахалын өмнө гарахыг амьдрал шаардаж байна.

Хоёр. АНД-н хамтын ажиллагаанд бүсийн орнуудын гүйцэтгэх, үүрэг хариуцлага

1. АНУ-ын үүрэг. АНУ-ын роль үүргийн талаар азийн олонхи орнууд ижил төсөөтэй байр суурьтай байж, АНД-д америкийн цэрэг зэвсгийн байршлыг үргэлжлүүлэн байлгах нь зэр зэвсгээр тэднийг хөөцөлдүүлэхгүй байлгаж, бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг хангах үндэс гэж үзэцгээж байна.

— Өөрийн улсын байр суурийн талаар Америкийн Батлан Хамгаалахын орлогч сайд Уильям Перри: «1945 оноос хойш Азид явуулж байгаа АНУ-ын бодлогын зорилго нь энх тайвныг сахиулах, тогтвортой байдлыг хангах, цэцэглэл Хөгжлийг дэмжихэд оршиж байв. Өнөөдөр эргэн тойрноо эргээд харахад зорилгодоо хүрчээ гэж би бодно. Хүйтэн дайны үе төгсгөл болсон ч бидний өмнөө тавьсан зорилго цаашид үргэлжлэх юм.

Азид тогтвортой байдлыг бий болгож бүс нутагт ардчилал болон эдийн засгийн дэвшилт байгууллагуудыг хөгжүүлэх нь манай үүрэг гэж үзэн Ази тивийн аюулгүй байдлыг сахиулахаар амалсан амлалтдаа үнэнч байх болно» гэжээ.

— Сингапурын Ерөнхий сайдаас «АНУ энэ бүс нутагт гол үүрэг ролийг гүйцэтгэх ёстой. АНУ энэ бүс нутагт хуучин шигээ үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх нь Хятад, Япон, Солонгос, АСЕАН-ы болон Энэтхэг-Хятадын хойгийн орнуудад туйлын аятай байдлыг бий болгож, өөр хоорондоо эвтэй харилцаа хөгжүүлэх боломжийг олгоно. Япон улс АНУ-ын аюулгүйн шүхэрт хоргодохоо байх гэж үзвэл тэд биеэ дааж өөрийгөө хамгаалах үйл ажиллагаа явуулж, тэр нь хил залгаа Хятад, Солонгос мэтийн оронд таалагдахгүй болно.

...АНУ эдийн засгийн хувьд хүчтэй байвал өөрийн үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулах боломжтой. Иймд АНУ-ын эдийн засгийг бусадтай өрсөлдөж чадахуйц хэмжээнд дахин хүргэх нь. Азийн орнуудын эрх ашигт бүрэн нийцэж байгаа юм» гэжээ.

— «Бүс нутгийн энх тайван, хөгжил цэцэглэлтийг зайлшгүй төвхнүүлэх үндсэн хүч бол манай бүс дэх АНУ-ын байршил, үйл ажиллагаа юм. 1993 оны 4 дүгээр сард би Вашингтонд айлчлахдаа уг асуудлыг ерөнхийлөгч Б. Клинтонтой дахин баталж ярилцсан юм» гэж Миязава японы ерөнхий сайд байхдаа мэдэгджээ.

— Тайландын ерөнхий сайдын орлогчоос «Ази, Номхон далай дахь АНУ-ын цэрэг зэвсгийн 40 гаруй жилийн хугацааны байршил нь, бүс нутагт таламжтай байдлыг бий болгож тодорхой хэмжээний ашиг шимээ өгсөн юм. АНУ-ын аюулгүйн шүхэр нь бүс нутгийн гишүүн орнуудын тогтвортой байдлыг хангаж, гаднын аюулаас гишүүн орнуудын чөлөөт зах зээлийг хамгаалж, түүнд цаашид хөгжих боломжийг олгож ирлээ» гэжээ.

— Шинэ Зеландын ерөнхий сайдаас «АНУ-ын цэргийн байршил нь бүс нутгийн аюулгүй байдлыг хангаж, бие биеийн эсрэг зэр зэвсэг худалдан авахуулаагүйд оршино. АНУ-ын амлалт (улс орнуудын аюулгүйн байдлыг хангах) урьдын адил хэвээр үргэлжлэх нь бүс нутгийн орнуудын сонирхолд, америкийн өөрийн эдийн засгийн аюулгүй байдлын эрх ашигт нийцэж байгаа юм шиг тохирч байгаа юм» гэжээ.

АНД дахь АНУ-ын роль үүргийн талаар бүс нутгийн гишүүдийн байр суурь ойролцоо ижил байгаа боловч зарим орон эсрэг бодол байр суурьтай байдгийг энд мөн дурьдая.

2. Японы үүрэг. Япон эдийн засгийн хэт их гүрний хувьд АНД-д чухал роль үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд цаашид ч гүйцэтгэх хандлагатай байна. Японы эдийн засгийн үүргийг олон орнууд хүлээн зөвшөөрч байхад зарим орон өнгөрсөн түүхийг эргэн санаж, цэрэг улс төрийн хувьд хүчтэй орон болохоос, болгоомжлох хандлага бас гаргаж байна. Гэхдээ Япон улсыг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүний нэг болж байр сууриа удахгүй эзэлнэ гэдэгт итгэж, дэмжсэн орон олон байна.

АНД дахь Японы үүргийн талаар. Сингапурын ерөнхий сайдаас «АНД-н эдийн засагт Япон хүчтэй нөлөөтэй байна. Түүнийгээ улс төрийн хүрээнд шилжүүлэн өргөтгөхөөр эрмэлзэж байна. Америкчууд Япон улсыг өөрсдийн заасан замаар явуулж бүс нутагт улам их роль үүрэг гүйцэтгэхүүлэхийг хүсч байна. Гэвч өөрийн үндэсний эрх ашиг, дэлхий дахинд өсөн нэмэгдэж байгаа байр сууриа харгалзахгүйгээр америкчуудын үгийг шууд дагах сонирхол Токиод байхгүй байна» гэж тэмдэглэжээ.

Япон, Хятад АНД-д удирдах роль үүрэг гүйцэтгэх ёстой гэсэн олон ургалч санааг ч зарим улс гаргаж байна. Энэ санааг бусад улс оронд одоогоор төдийлөн дэмжихгүй байна. Цаашид АНД-дахь Япон, Хятадын үүрэг ямар байх нь тэднээс өөрсдөөс нь хамаарах билээ.

АНД-н орнуудын хамтын ажиллагааг дараах дөрвөн салбарт явуулж тогтвортой байдал, цэцэглэл хөгжилтийг бий болгохыг Япон хүсч санаачлага гарган ажиллаж байна. Үүнд:

- а) Бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг хангахын тулд бүсийн улс төр, хөгжлийн эрчимтэй хамтын ажиллагааг дэмжих;
- б) нээлттэй эдийн засаг, хөгжлийн эрчимтэй хамтын ажиллагааг дэмжих;
- в) хүн бүрийн хүсч мөрөөдөж байдаг бүрэн эрх чөлөө, хөгжил дэвшил, байгаль орчныг тэр хэвээр нь хадгалан үлдээх;

г) Энэтхэг-Хятадын хойгт энх тайван, цэцэглэл, хөгжилтийг бий болгох зэрэг болно. Японы , энэхүү санал нь ардчилал, чөлөөт зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх журмаар АНД-н хамтын ажиллагаа, энх тайвныг бэхжүүлэхэд чиглэгдэж байгаа бөгөөд эдийн засгийн хэт их гүрний хувьд өөрийн санал санаачилгыг хэргэжүүлэхэд санхүүгийн тусламж дэмжлэг үзүүлэн хамтын ажиллагаа явуулахад бэлэн байгаагаа харуулж байна.

3. Орос, Хятад, Энэтхэгийн үүрэг. АНД-д энэ гурван орны үүрэг асар их бөгөөд цаашдаа улам өсөх төлөвтэй байна. Орост эдийн засгийн шинэчлэл амжилттай дуусч, дотоод улс төрийн байдал, тогтворжсон үед АНД-д өөрийн байр сууриа зохих ёсоор эзэлж эдийн засгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцохыг бүс нутгийн гишүүд хүлээж байна.

Хятад, Энэтхэг нь дэлхийн хүн ам олонтой хоёр том гүрэн бөгөөд тэдний эдийн засаг гадаад орчинд нээгдэж, эдийн засгийн нээлттэй бодлого явуулж байгаа нь АНД-н орнуудтай эдийн засгийн интеграцид орох бүрэн боломжийг бий болгож цаашдын эрч хүчээ авах эхлэлийг тавьж байна.

4. Улс орнуудын хоёр талын харилцааны үүрэг. АНД-н ирээдүйн хөгжил, хамтын ажиллагаанд АНУ-ОХУ, АНУ — Япон, Хятад-Япон, ОХУ-Хятад, Япон-ОХУ, Энэтхэг-Хятад, хоёр Солонгосын хоорондын харилцаа туйлын чухал үүрэг гүйцэтгэх юм. Тэдгээрийн хоорондын өнөөгийн болон цаашдын харилцаанаас АНД-н орнуудын хамтын ажиллагааны хувь заяа хөгжил хамаарна.

Гадны хүмүүсийн бичиж байгаагаар, АНД-д АНУ — Японы харилцааны дараа Хятад-Японы харилцаа зүй ёсор орж байгаа бөгөөд ирэх 15-20 жилд Хятад-Японы харилцаа нь бусад улсуудын харилцаанаас илүү ач холбогдолтой болох төлөвтэй байгаа аж. Орос, Японы хооронд байдаг умарт нутгийн асуудал нь тэднийг АНД-д хамтран, идэвхтэй харилцан ашигтай ажиллахад саад болж байна. Түүнээс Орос, Япон өөрсдөө л алдахаас өөр хэн ч алдахгүй юм.

Гурав. XXI зуунд АНД-н орнуудын худалдаа, эдийн засгийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг

АНД-н бүс нутаг дэлхий дахинд тэргүүлж, XXI зууныг өөрийн зуун болгоход тэнд оршин тогтнож байгаа эдийн засгийн байгууллагууд гол үүрэг гүйцэтгэх ёстой билээ. Түүнд АПЕК, ПЕКК, АСЕАН, СААРК болон «Зүүн Азийн эдийн засгийн бүлэглэл», Зүүн хойт Азийн орнуудын хамтын ажиллагааны байгууллагууд зүй ёсоор орно.

1. АПЕК (Азийн Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага) - ийг бий болгох саналыг , Автралын ерөнхий сайд Р. Хоук 1989 оны 1 дүгээр сард Сеулд айлчлахдаа анхлан дэвшүүлж, улмаар тэр нь өнөөдөр өөртөө 17 гишүүнийг багтаасан, АНД-н бүс нутгийн орнуудын худалдаа, эдийн засгийн бодлогыг тодорхойлдог зөвлөлдөх чуулган болоод байна. АНД-н орнуудын эдийн засгийн хөгжил хурдассан, нөгөө талаас Хойд Америк, Баруун Европт худалдаа эдийн засгийн явцуу бүлэглэл байгуулагдсан, түүнчлэн социалист гэгдэж байсан орнууд дэлхийн эдийн засгийн харилцаанд идэвхтэй оролцох хандлагатай болсон зэрэг байдлыг Р. Хоук харгалзан уг саналыг гаргажээ. Хоукийн саналд анхандаа АНУ, Канадыг уг байгууллагад оролцуулахгүйгээр тусгасан боловч тэд АНД-н орнуудтай худалдаа эдийн засгийн харилцаа өргөн явуулдаг АНД-н орон гэдгээ баталсанаар үл барам Папуа Шинэ Гвиней, Мексикийг гишүүнээр элсүүлээд байна.

АПЕК-ийн анхны уулзалт Австралийн Канберрад 1989 оны 11 дүгээр сард болсоноос хойш жил бүр тогтмол явагдаж ирлээ. Сүүлчийн 5 дугаар уулзалт 1993 оны 11 дүгээр сард АНУ-ын Сиэтлд болов. Энэ удаагийн уулзалт АНУ-ын санаачилгаар гишүүн орнуудын төр, засгийн тэргүүдийн хэмжээнд болж АПЕК-ийн эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалт болон байгууллагын ирээдүйн хөгжил зохион байгуулалт хамтын ажиллагааны зорилгыг ярилцсанаар онцлогтой болж, АНД-д уг байгууллага шаардлагатайгаа харуулав.

Харин АСЕАН-ы гишүүдийн албаны хүмүүс уг уулзалтад эргэлзэж, хэвлэлдээ өөр өөрсдийн үнэлэлт дүгнэлтийг өгөв. Тэдний гол санаа нь «Европын холбоо», НАФТА» (Хойт Америкийн чөлөөт худалдааны бүс) шиг АПЕК-ийг худалдааны явцуухан бүлэглэл болчихоос АСЕАН-ы гишүүд сэрэмжилж, АСЕАН бол биеэ даасан улс төр, эдийн засгийн байгууллага гэдгээ онцлон тэмдэглэж, өөрсдийн биеэ даасан байдлаа хэвээр хадгалж үлдэхэд оршиж байв.

АНУ-ын байр суурийг төрийн нарийн бичгийн дарга У. Кристофер" тайлбарлаж, АНУ нь АНД-г нээлттэй бүс нутаг хэвээр байлгаж, АПЕК-ийг шинээр бүтээн байгуулах чиглэлтэй эвсэл болгохын төлөө байгаагаас худалдааны явцуухан бүлэглэл болохын төлөө байгаа юм биш гээд, АПЕК нь бүс нутгийн чөлөөт худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжиж, бүс нутгийн гишүүдийн хамтын дэмжлэгтэйгээр шийдвэрлэгдэх эрчим хүч, байгаль орчныг хамгаалахад хамтын ажиллагаагаа голлож, түүнчлэн бүс нутгийн гишүүдийг холбодог харилцаа холбооны шугам, дэд бүтцийг сайжруулахад гол анхаарлаа тавин ажиллах шаардлагатайг онцлон тэмдэглэсэн нь нийтийн сонирхолд нийцэв бололтой.

Япон болон Азийн худалдаа хөгжсөн «барууд» дэлхий дээр явцуухан худалдааны бүлэглэл, бий болж байгаан эсрэг байгаа бөгөөд тэдгээр бүлэглэл нь чөлөөт худалдааг хаан боогдуулна гэж үзэж, тэдгээрийг нээлттэй дэлхий дахины олон талт систем болгохын төлөө зогсож байна. Иймд АПЕК-ийг мөн нэгэн адил худалдааны явцуухан бүлэглэл болохоос тэд сэрэмжилж байдаг аж.

Манай улс АПЕК-т гишүүнээр элсэн орох явдал туйлын ач холбогдолтой. Харин манай орны хөгжлийн түвшин, гадаад худалдааны эргэлт, далайд гарцгүй байдал зэргийг харгалзан АПЕК-т элсэхэд тэд төдийлөн сонирхол гаргаж дэмжихгүй байна. Иймд бид тэдний сонирхлыг татах зүйлийг өөртөө бий болгож, экспортын хэмжээг өргөтгөн нэмэгдүүлэх олон үйлдвэр байгуулахыг хөхүүлэн дэмжсэн гадаад эдийн засгийн бодлого явуулах шаардлага урган гарч байна.

2. ПЕКК (Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны бага хурал) нь Японы ерөнхий сайд Охира, Австралийн ерөнхий сайд Фразер нарын санаачилгаар 1980 онд Номхон далайн сав, нутгийн орнуудын эдийн засгийн харилцаа уялдаа холбоо, хамаарал, түүний хүчин чадал, ирээдүйн байдлаас үндэслэн байгуулагджээ.

ПЕКК нь Зүүн өмнөд Ази, Зүүн хойт. Ази, Хойт Америкийн Номхон далайн өмнөд хэсгийн гэх мэтчилэн бүсчилсэн салбартай.

ПЕКК нь АНД-н худалдаа, эдийн засагт нөлөөтэй, засгийн газрын бус байгууллага бөгөөд түүний үйл ажиллагаа газар авч дэлгэрэн хөгжиж байна.

Уг байгууллагад манай орны Засгийн газрын бус байгууллагууд оролцож үйл ажиллагаанд оролцоход илүү тохиромжтой.

3. Зүүн Азийн эдийн засгийн бүлэглэл, Зүүн хойт Азийн хамтын ажиллагааны байгууллага: Малайзийн ерөнхий сайд Махатхир Мохамад Зүүн Азийн эдийн засгийн бүлэглэл байгуулах саналыг 1990 оны 12 дугаар сард гаргаж, АСЕАН болон Зүүн Азийн үйлдвэр хөгжсөн

орнууд мөн Япон, Хятадыг оролцуулсан Азийн чөлөөт худалдааны бүс байгуулах оролдлогыг хийв. «НАФТА», «Европын холбоо» хүчтэй болоод худалдааны бүлэглэл бий болох үед энэ байгууллагын үйл ажиллагаа АНД-д идэвхтэй болж болох юм.

Зүүн хойт Азийн (ЗХА) орнуудыг нэгтгэсэн худалдаа эдийн засгийн байгууллага байгуулах идэвхтэй оролдлого гишүүн орнууд гаргаж байна. XXI зуунд ЗХА-ийн улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага бий болоход эргэлзэх зүйлгүй. Түүний үндэс суурийн эхлэл болсон «Түмэн голын» төсөл нь Түмэн голын бүсийн хөгжлийн корпораци, Засгийн газар хоорондын зохицуулах, зөвлөлдөх комисс байгуулах явцдаа байна.

ЗХА-ийн хамтын ажиллагааны бүсд манай орон ямар хэмжээгээр аль салбарт хэрхэн оролцох, өөрийн ирээдүйн төлөвөө бид одооноос нарийвчлан боловсруулж гаргах явдал чухлаар тавигдаж байна. АНД-д ЗХА-ийн эзлэх хувийн жин, үүрэг маш ихээр өсч тэргүүлэх байр сууриа XXI зуунд эзлэх төлөвтэй байгааг бид одооноос бодолцон ажиллах шаардлага гарч байна. Иймд уг асуудлыг зангидан зохицуулж, ЗХА-д ажиллах өөрийн орны хэтийн төлөвийг бодон, Засгийн газрын дэргэд тусгай хороо байгуулах цаг болсон мэт санагдана.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. 1993 оны 5 дугаар сард Токиод «Дэлхий дахины өөрчлөгдөж байгаа дэг журам дахь Азийн роль» сэдвээр болсон олон улсын бага хурал дээр Ази, Номхон далайн орнуудын төр засгийн тэргүүд, орлогчдын хэлсэн үг.
2. Far Eastern Economic Review сэтгүүлийн
1991 оны 7 дугаар сарын 25,
1993 оны 4 дүгээр сарын 15
1993 оны 3 дугаар сарын 25
1993 оны 3 дугаар сарын 18
1993 оны 3 дугаар сарын 11
1993 оны 9 дүгээр сарын 2
1993 оны 12, 11-р сарын дугаарууд
3. The Economist сэтгүүлийн 1993 оны 3, 4, 10, 11-р сарын дугаарууд
4. Pacific Affairs 1989 оны № 4

ВЬЕТНАМ, МОНГОЛЫН ХАРИЛЦАА ӨНӨӨГИЙН ШАТАНД

Ле Ван Зыенг*
С. Дашцэвэл

Дэлхийн үйлдвэрлэх хүч өнөө үед дээд хэмжээгээр интернационалчлагдаж улмаар тэр нь өнөөгийн улс төр, эдийн засгийн харилцаанд нөлөөлж байна. Эдүгээ дэлхий ертөнц нэгдсэн нэгэн зах зээл болон хувирч тэрхүү дэлхийн нэгдмэл зах зээл “Дэлхийн хэмжээний хөдөлмөрийн хуваарийг шаардаж эхлээд байна. Зарим судлаачид улс төрчдийн үзэж буйгаар хөдөлмөрийн хуваарь хэдийчинээ өндөр байна харилцан хамаарал төдийчинээ их байх бөгөөд харилцан хамаарал нь улс үндэстнүүдийн өөрийн өвөрмөц шинж төрхийг хамгаалж хөгжүүлэх боломжийг алдахгүй харин ч дэлхийн хэмжээнд улам бүр нягт

* ДДОУС-ын Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

* ДДОУС-ын Хүрээлэнгийн аспирант